



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2016 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 47

Мандалговь

Г Хөрөнгө данснаас хасах тухай Г


Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2.1, 5.8.г дэх заалтыг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Дэлгэрхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй хавсралт дахь 3,331,184 /гурван сая гурван зуун гучин нэгэн мянга нэг зуун наян дөрөв/ төгрөгийн анхны өртөгтэй, элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнээ нөхсөн хөрөнгийг акталж, хөрөнгөнөөс гарах төмрийг хаягдал төмрийн үнээр худалдах, 2,863,000 /хоёр сая найман зуун жаран гурван мянга/ төгрөгийн анхны өртөгтэй, 906,616 /есөн зуун зургаан мянга зургаан зуун арван зургаа/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 6 настын жорлонг акталж устган, акталснаас гарах материалыг эргэлтийн хөрөнгөнд бүртгэж авахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө актлах ажлыг сумын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор зохион байгуулж, хаягдал төмрөөр худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд тушааж, актлагдсан хөрөнгийг зохих хууль журмын дагуу данс бүртгэлээс хасахыг Дэлгэрхангай сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Ж.Өлзийжаргалд даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын даргын үүрэг гүйцэтгэгч С.Ууганбаярт үүрэг болгосугай.


ДАРГА



С.СҮХБААТАР

0100184

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 20.60ны 1.2 сарын ... өдрийн ... Дугаар тогтоолын хавсралт



Аглах хөрөнгийн жаргсаалт

№	Хөрөнгийн нэр	Тоо ширхэг	Ашиглалтанд орсон он	Ашигласан хугацаа	Үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Зил 130	1	1999	17	3,259,184.0	3,259,184.0	3,259,184.0	-
2	Чиргүүл	1	2001	15	72,000.0	72,000.0	72,000.0	-
Дүн						3,331,184.0	3,331,184.0	-